

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

## ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 1 дүүгэр  
сарын 29-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

“Билүү хөгжил” хоршоонд хадгаламж, зээлийн  
үйл ажиллагаа эрхлэх тусгай  
зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.4, Хоршооны тухай хуулийн 48<sup>1</sup>.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг батлах тухай нөхцөл шаардлага”-ыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Билүү хөгжил” хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Билүү хөгжил” хадгаламж, зээлийн хоршоо /Ж.Тилиген/-т үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ